



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Татвар төлөгч, татварын албаны хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий “Маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам батлах тухай” Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 22 дугаар тогтоолыг 2020 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

У.ХҮРЭЛСҮХ

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан гомдол, гомдол гаргах хугацаа сэргээхтэй холбоотой хүсэлтийг Маргаан таслах зөвлөлөөр хянан шийдвэрлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Маргаан таслах зөвлөл нь татварын акттай холбоотой гомдол (цаашид “гомдол” гэх), Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.2-т заасан хүсэлт (цаашид “хүсэлт” гэх)-ийг хянан шийдвэрлэхдээ энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3.Маргаан таслах зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, татвар төлөгчийн болон татварын албаны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, татвар төлөгчийн нууцыг чанд хадгалах зарчим баримтална.

1.4.Маргаан таслах зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөл, аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлөөс бүрдэнэ.

1.5.Маргаан таслах зөвлөл нь Татварын ерөнхий хуулийн 46.1-д заасан гомдлыг татвар төлөгчийн гомдлын хүрээнд хянан шалгаж шийдвэрлэнэ.

1.6.Гомдол, хүсэлт нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

Хоёр.Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа.

2.1.Маргаан таслах зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөл нь 11, аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2.Аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус томилж, чөлөөлнө.

2.3.Маргаан таслах зөвлөлийн гишүүн нь Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасан шаардлагыг хангасан байна.

2.4.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга /цаашид “нарийн бичгийн дарга” гэх/-ыг Татварын ерөнхий хуулийн 46.8-д заасны дагуу томилох бөгөөд Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Татварын ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.13-т заасны дагуу ажиллана.

2.5.Маргаан таслах зөвлөлийн дэргэд татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх зорилгоор Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.7-д заасан хараат бус магадлагч /цаашид “магадлагч” гэх/ ажиллах бөгөөд магадлагчийг тухайн шатны татварын албаны даргын тушаалаар 3 жилийн хугацаагаар томилно. Магадлагчаар нэг удаа улируулан ажиллуулж болно.

2.6.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн дотоод ажлыг хариуцан, зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж, хуралдааны тэмдэглэл хөтөлнө. Хуралдааны тэмдэглэлд Маргаан таслах зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

2.7.Маргаан таслах зөвлөл дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.7.1.гомдлыг харьяаллын дагуу хүлээн авах, татгалзах, буцаах, хянан шийдвэрлэх;

2.7.2.шаардлагатай тохиолдолд орчуулагч, шинжээч оролцуулах;

2.7.3.хянан шийдвэрлэж байгаа асуудал нь гэмт хэргийн шинжтэй бол зохих журмын дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;

2.7.4.маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах, татварын хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж гаргаж, татварын албадад хүргүүлэх;

2.7.5.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөл нь аймаг, нийслэлийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах.

2.8.Маргаан таслах зөвлөл нь маргааны оролцогч талуудаас бусад этгээдэд, гомдол, хүсэлттэй холбогдох мэдээллийг танилцуулах үүрэг хүлээхгүй.

2.9.Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан үндэслэлээр гомдол гаргасан тохиолдолд энэ журмын 4.1-д заасан хугацааг харгалзахгүй уг гомдлыг хүлээн авна.

2.10.Татвар төлөгчөөс татварын актад гомдол гаргах хугацааг зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн бол Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.2-т заасан хугацаанд татварын төлөгчийн хүсэлтийг Маргаан таслах зөвлөл хүлээн авна

2.11.Маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаатай холбогдох зардлыг тухайн маргаан таслах зөвлөлийн харьяалж байгаа татварын алба хариуцна. Маргаан таслах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргад хуралдсан цагаар нь хөлс олгоно. Цагийн хөлсний хэмжээг томилсон эрх бүхий албан тушаалтан тогтооно.

Гурав.Маргааны оролцогч талууд

3.1.Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд татвар төлөгч, татварын актыг үйлдсэн татварын улсын байцаагч оролцох бөгөөд тэдгээрийг маргааны оролцогч тал гэнэ.

3.2.Татвар төлөгч нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах эрх, үүрэгтэй оролцоно:

3.2.1.өөрийн гаргаж өгсөн баримт бичгийн баталгаажсан хуулбар болон эх хувийг буцаан авах;

3.2.2.Маргаан таслах зөвлөлийг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийг шаардах;

3.2.3.татвар төлөгч нь Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй танилцаж, үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо шүүхэд гаргах;

3.2.4.хуралдаанд өөрийн биеэр буюу итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөх, өмгөөлөгчийг оролцуулах;

3.2.5.маргаан бүхий акттай холбоотой тайлбар, нотлох баримтыг Маргаан таслах зөвлөлд гаргаж өгөх бөгөөд орчуулгын зөрүүтэй байдлаас үүсэх үр дагаврыг өөрөө хариуцах;

3.2.6.Татварын ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т заасан урьдчилгаа татварыг төлж баримтыг гомдолд хавсаргах;

3.2.7.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3-т зааснаар урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг 2 жилийн хугацаанд төлөөлөхгүй байх;

3.2.8.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

3.3.Татварын улсын байцаагч маргаан бүхий акттай холбоотой тайлбар, нотлох баримтыг Маргаан таслах зөвлөлд гаргаж өгч, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн эрх үүрэгтэй оролцоно.

3.4.Татварын акт үйлдсэн татварын улсын байцаагч, хянан баталгаажуулсан нэгжийн дарга маргаан таслах хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн биеэр оролцох бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулж болно.

3.5.Маргаан таслах зөвлөл нь маргааны оролцогч тал болох иргэн нас барсан тохиолдолд түүний өв залгамжлагчийг, хуулийн этгээд өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд шинээр үүссэн хуулийн этгээдийг тэдгээрийн хүсэлтээр маргааны оролцогч талаар тооцож болно. Энэ тохиолдолд тухайн этгээд нь энэ журмын 3.2-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Дөрөв.Гомдолд хүсэлт гаргах, түүнийг хүлээн авах, татгалзах

4.1.Татвар төлөгч, эсхүл түүний эрх олгосон итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөх нь татварын актыг гардаж авснаас хойш Татварын ерөнхий хуулийн 12.1.6, 43.1, 72.4-т заасан хугацаанд дараах харьяаллын дагуу гомдол, хүсэлтээ гаргана.

4.1.1.татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын татварын хяналт шалгалт хариуцсан нэгж болон том татвар төлөгчтэй харилцах нэгжийн гаргасан шийдвэртэй холбоотой гомдол, хүсэлтийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд;

4.1.2.нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн гаргасан шийдвэртэй холбоотой гомдол, хүсэлтийг нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлд;

4.1.3.аймгийн татварын хэлтсийн гаргасан шийдвэртэй холбоотой гомдол, хүсэлтийг аймгийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлд;

4.1.4.Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй холбоотой гомдол, хүсэлтийг шүүхэд.

4.2.Гомдол, хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд түүнд гомдол гаргагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан байна.

4.3.Гомдол, хүсэлтэд дараах мэдээллийг тусгасан байна:

4.3.1.гомдол, хүсэлтийг аль маргаан таслах зөвлөлд гаргаж байгаа;

4.3.2.гомдол гаргагчийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол нэр, оршин байгаа газрын хаяг;

4.3.3.хариуцагчийн нэр, оршин байгаа газрын хаяг;

4.3.4.гомдлын шаардлага, түүний үндэслэл;

4.3.5.хавсаргасан баримт бичгийн жагсаалт;

4.3.6.холбоо барих утас, факс, цахим хаяг.

4.4.Гомдолд дараах нотлох баримт бичгийг хавсаргана:

4.4.1.итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөх гомдол гаргасан бол төлөөлөх эрх олгосон баримт бичиг болон итгэмжлэл;

4.4.2.энэ журмын 3.2.6-т заасан мөнгөн дүнг төсөвт төлсөн баримт;

4.4.3.гомдлын шаардлага, үндэслэлийн нотлох баримтыг цаасаар болон цахимаар.

4.5.Гомдол, хүсэлтийг хүлээн авахдаа дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1.гомдол, хүсэлтийг тухайн татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч, хүлээн авсан огноо, цаг, минут, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудасны тоог тэмдэглэн, бүртгэх;

4.5.2.гомдол нь энэ журмын 4.3-т заасан мэдээллийг бүрэн ирүүлээгүй тохиолдолд хүлээн авсан магадлагч гомдол гаргагчид уг мэдээллийг ирүүлэх боломж олгох;

4.5.3.Маргаан таслах зөвлөлд гаргасан гомдол, хүсэлт болон бусад баримт бичиг, мэдээллийг хянаж, 3 хоногийн дотор харьяаллыг тогтоож, харьяаллын бус гомдлыг буцаах;

4.5.4.гомдол гаргагч тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гомдол, хүсэлтийн энэ журмын 3.2.6-д заасан урьдчилгаа төлбөрийг төлөөгүй тохиолдолд гомдлыг буцаах.

4.6.Маргаан таслах зөвлөл нь дараах тохиолдолд гомдлыг хүлээн авахаас татгалзана:

4.6.1.маргаан таслах зөвлөл нь Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан хянан шийдвэрлэх чиг үүргийн бус;

4.6.2.гомдлыг шүүх хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол гарсан;

4.6.3.гомдол гаргагч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан боловч эрх, үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй;

4.6.4.энэ журмын 4.1-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн;

4.6.5.Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.2-т заасан хугацааг хэтрүүлсэн;

4.6.6.Татварын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлд заасан “Харилцан тохиролцох журам”-ын хүрээнд хүсэлт гаргасан.

4.7.Гомдлыг энэ журмын 4.5, 4.6-д заасан үндэслэлээр буцаасан, хүлээн авахаас татгалзсан тохиолдолд хариуг албан бичгээр гомдол гаргагчид хүргүүлнэ.

4.8.Маргаан таслах зөвлөл гомдлыг хүлээн авсан нь татварын актын биелэлтийг түдгэлзүүлэх үндэслэл болгохгүй.

Тав.Гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэлтгэх

5.1.Магадлагч нь татвар төлөгчийн гомдол хүсэлтийг хянан шийдвэрлэх зорилгоор дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.2.Гомдол гаргасан татвар төлөгч магадлагчийн шаардсан нотлох баримтыг ирүүлээгүй тохиолдолд ирүүлсэн нотлох баримтын хүрээнд хянан магадалж, дүгнэлт гаргана.

5.3.Нарийн бичгийн дарга нь энэ журмын 5.1-д заасан чиг үүргийг дангаар болон магадлагчтай хамтран хэрэгжүүлж болно.

5.4.Нарийн бичгийн дарга нь хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө зөвлөлийн дарга, гишүүдэд хуралдааны тов, төлөвлөгөө болон хэлэлцэх асуудлын танилцуулга, материалыг хүргүүлж

5.5.Нарийн бичгийн дарга нь маргааны оролцогч талуудад хуралдааны товыг утсаар болон цахим хэлбэрээр зарлаж, тэмдэглэл үйлдэнэ.

5.6.Маргаан таслах зөвлөлийн магадлагч нь энэ журмын 5.1-д заасан үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.6.1.гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн болон бусад баримт бичиг, мэдээ, судалгааг татварын улсын байцаагч, татвар төлөгч, холбогдох бусад этгээдээс гаргуулж авах;

5.6.2.маргааны оролцогч талуудыг сонсох, тайлбар гаргуулах;

5.6.3.энэ журмын 2.8.2-т заасан мэргэжилтнийг оролцуулан дүгнэлт гаргуулах;

5.6.4.гуравдагч этгээдээс тайлбар авч нотлох баримт гаргуулах;

5.6.5.гомдолтой холбоотой бусад байгууллагын шийдвэртэй танилцах, хуулбарлах;

5.6.6.татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийг ашиглах;

5.6.7.мэдээлэл харилцан солилцох асуудал хариуцсан нэгжээс шаардлагатай тохиолдолд мэдээлэл гаргуулах;

5.6.8.хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

5.6.9.цуглуулсан нотлох баримтыг үнэлэн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж, гаргасан дүгнэлтийг хуралдаанаар хэлэлцүүлэх.

Зургаа.Гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэх ажиллагаа

6.1.Маргаан таслах зөвлөл нь энэ журмын 4.1-д заасан гомдол, хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл зөвлөлийн дарга уг хугацааг нэг удаа 30 хоногоор сунгаж болно.

6.2.Маргаан таслах зөвлөлийн хуралдаанд маргааны оролцогч талууд болон Маргаан таслах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, болон магадлагч оролцоно. Хуралдааныг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хүчинтэйд тооцно.

6.3.Хуралдааныг дэгийн дагуу явуулах бөгөөд дэгийг Маргаан таслах зөвлөлийн дарга батална.

6.4.Хуралдааныг Маргаан таслах зөвлөлийн дарга даргална. Маргаан таслах зөвлөлийн даргын эзгүйд хуралдааныг Маргаан таслах зөвлөлийн даргын үүрэг болгосноор түүний үүргийг зөвлөлийн гишүүн даргална.

6.5.Маргаан таслах зөвлөлийн хуралдааны товыг маргааны оролцогч талуудад зарласан боловч тэдгээр нь Татварын ерөнхий хуулийн 6 дүгээр зүйлийн 6.1.41-д заасан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд ирээгүй нь гомдлыг хуралдаанаар хэлэлцэн шийдвэр гаргахад саад болохгүй.

6.6.Маргаан таслах зөвлөл нь гомдол, хүсэлтийг хуралдаанаараа хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6.7.Энэ журмын 6.5-д заасан гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд дахин санал хураана. /мөн журмын 1.3-т заасан зарчмыг баримтлан шийдвэрлэнэ/

6.8.Гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ:

6.8.1.татвар төлөгчийн ирүүлсэн гомдолд хамаарах асуудал нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-т заасны дагуу маргааныг хянан шийдвэрлэх боломжгүй;

6.8.2.Татварын ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.11-д заасан үндэслэлээр нэг удаа.

6.9.Энэ журмын 6.7-д зааснаар гомдлыг түдгэлзүүлсэн нь тухайн гомдлыг дахин хянан шийдвэрлэхгүй байх үндэслэл болохгүй.

Долоо.Маргаан таслах зөвлөлийн шийдвэр

7.1.Маргаан таслах зөвлөл гомдол, хүсэлтийг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 7.1.1.татварын актыг өөрчлөх;
- 7.1.2.татварын актыг хүчингүй болгох;
- 7.1.3.татварын актыг хэвээр үлдээх;
- 7.1.4.татварын актыг түдгэлзүүлж татварын албанд буцаах.

7.2.Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хуралдаанд оролцогчдод уншиж сонсгох бөгөөд тухайн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхийг татвар төлөгчид тайлбарлана.

7.3.Маргаан таслах зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд тогтоолд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гарын үсэг зурна.

7.4.Тогтоол нь тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэнэ:

7.4.1.тодорхойлох хэсэгт тогтоолыг хэзээ, хаана, ямар маргаан таслах зөвлөл гаргаж байгаа, хурлын дарга, оролцсон гишүүд, нарийн бичгийн дарга, маргааны оролцогч талуудыг нэрлэн заана. Гомдол, хүсэлтийн шаардлага, маргааны оролцогч талуудын тайлбарын агуулгыг тус тус бичих;

7.4.2.үндэслэх хэсэгт гомдлыг хянан шийдвэрлэхэд баримталсан нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг Маргаан таслах зөвлөлөөс хэрхэн үнэлж байгаа тухай бичих;

7.4.3.тогтоох хэсэгт гомдлын хянан шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, гомдол, хүсэлтийн шаардлагыг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгосон, гомдол, хүсэлтийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон тухай бичнэ.

7.5.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь тогтоолыг маргаанд оролцогч талуудад 10 хоногийн дотор гардуулж, гардуулсан тухай тэмдэглэл үйлдэж, бүртгэнэ.

7.6.Татвар төлөгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөхөд тогтоолыг энэ журмын 7.5-д заасан хугацаанд гардуулах боломжгүй, эсхүл гардан аваагүй бол маргаан таслах зөвлөл уг хугацаа өнгөрснөөс хойш 7 хоногийн дотор татварын албанд бүртгүүлсэн шуудангийн хаягаар илгээнэ.

7.7. Тогтоолыг энэ журмын 7.6-д заасны дагуу хүргүүлсэн нь Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд зааснаар маргааны оролцогчид мэдэгдсэнд тооцно.

7.8.Маргаан таслах зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвхөн шүүхийн шийдвэрээр өөрчилнө.

7.9.Маргаан таслах зөвлөлийн хүчин төгөлдөр шийдвэрийг татвар төлөгч, татварын алба, татварын улсын байцаагч, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

Найм.Сонирхлын зөрчил

8.1.Гомдол хүсэлтийг хянан магадлах, шийдвэрлэх ажиллагаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасныг баримтална.

8.2.Маргаан таслах зөвлөлийн гишүүд гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэхийн өмнө Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

8.3.Гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэхийн өмнө ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7, 8.8-д заасныг мөрдөнө.

8.4.Маргаан таслах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, магадлагч дараах тохиолдолд гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд үл оролцох бөгөөд өөрөө татгалзан гарах үүрэгтэй:

8.4.1.маргааны оролцогч тал болох иргэн, татварын улсын байцаагчийн гэр бүл, төрөл садан бол;

8.4.2.маргааны оролцогч тал болох хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч бол;

8.4.3.гэр бүл, төрөл садан нь маргааны оролцогч тал болох хуулийн этгээдийн эрх бүхий этгээд /Төлөөлөн удирдах зөвлөл, хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн/ бол.